

## ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ЭТГЭЭД ШҮҮХЭД ИТГЭМЖЛЭЛЭЭР ТӨЛӨӨЛӨХТЭЙ ХОЛБОГДСОН ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд (ХХША) бусдыг төлөөлөх нөхцөл байдлыг судлан, тулгамдсан асуудлыг шийдэх эрх зүйн зохицуулалтыг тодорхойлох явдал нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрхийг хангах хууль зүйн баталгааг бий болгоход чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн иргэд мэргэжлийн, чанартай, хууль зүйн туслалцаа авах буюу өмгөөлөгч авах эрхээ эдлэх; аливаа хэрэг маргаанаа шүүхээр үнэн зөв, бүрэн бодитой шийдвэрлүүлэх; шүүх, хуулийн байгууллага, хуульч, өмгөөлөгчид итгэх иргэдийн итгэл нэмэгдэх; хуульчийн мэргэжлийн нэр

хүнд өсөх зэрэг олон талын эерэг нөлөөтэй. Тиймээс хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхгүй этгээд итгэмжлэлийн үндсэн дээр иргэн болон хуулийн этгээдийг ХХША-д төлөөлж, хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх буюу өмгөөлөл хийж байгаа талаар хууль зүйн мэргэжилтнүүдийн байр суурь, хандлагыг тандах, тулгамдаж буй асуудлыг шийдэх арга замыг тогтоох судалгаа хийж тодорхой дүгнэлтэд хүрлээ. Судалгааг анкет асуулга, фокус бүлгийн хэлэлцүүлэг, ганцаарчилсан ярилцлагын аргаар явуулж, үр дүнг статистик мэдээ болон гадаад орнуудын эрх зүйн тогтолцоотой харьцуулан судлав.

### МОНГОЛ УЛСЫН ӨНӨӨГИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын захиргааны болон иргэний хэргийн шүүхэд ХХША-д хэргийн оролцогч өөрийн биеэр болон бусдаар төлөөлүүлэн оролцох эрхзүйн орчин

	Хувилбар I	Хувилбар II	Хувилбар III
Хэлбэр	ХХША-ны талууд өөрийн биеэр дангаараа оролцох.	Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэх.	Өмгөөлөгчийн туслалцаатайгаар ХХША-д оролцох.
Үндсэн эрх	Өөрийгөө өмгөөлөх эрх	Өөрийгөө өмгөөлөх эрх (Өөрийгөө өмгөөлөх эрхэд шууд хамааруулах эсэх дээр онолын маргаантай асуудал байдаг.)	Эрх зүйн туслалцаа авах эрх
Үндсэн эрхийн үзэл баримтлал	Хувь хүний хүсэл зоригийг хүндэтгэх, хувь этгээдийн бие даасан байдлыг хангах.		Нийтийн тогтолцоог бүрэн гүйцэд ашиглах боломжоор хангах.
Үндсэн эрхийн шинж	Негатив		Позитив
Онцлог тал	Мэргэжлийн туслалцаа шаардлагагүй, эсвэл өөрийгөө өмгөөлөх бүрэн чадамжтай, мэдлэгтэй.	Өөрөө биечлэн оролцох боломжгүй, мэргэжлийн туслалцаа авах шаардлагагүй.	Мэргэжлийн туслалцаа авах шаардлагатай.



М.ЦЭНД-ОЧИР  
/LL.M/  
Шунхлай ХХК-ийн хуульч. Иргэний эрх зүй, Иргэний процессын эрх зүй, Байгаль Орчны эрх зүй, Үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд судалгаа хийдэг.



Н.НОРОВСАМБУУ  
/LL.M/  
МУИС Хууль зүйн сургуулийн багш. Иргэний процессын эрх зүй, Иргэний процессын эрх зүй дэх нотолгооны онол, арга зүй, иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэл чиглэлээр хичээл зааж, судалгаа хийдэг.



Ж.СОДНОМДАРЖАА  
Монголын хуульчдын холбооны гишүүн өмгөөлөгч. Захиргааны эрх зүйн хүрээнд гаалийн эрх зүй, уул уурхай, ашигт малтмалын, бүртгэлийн, газрын болон иргэний эрх зүйн чиглэлээр судалгаа хийдэг.

Үндсэн хуульд үзэл баримтлалын хувьд хууль зүйн туслалцааг зөвхөн мэргэжлийн өмгөөлөгч үзүүлэх талаар тусгагдсан байдаг. Өмгөөлөгч биш этгээд бусдыг шүүхэд төлөөлөх тогтолцоо нь талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийн биеэр оролцох болон өмгөөлөгчийн туслалцаатайгаар оролцох гэсэн сонголтуудын дундын хувилбар юм. Гэвч практикт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэх харилцаа болон өмгөөлөгчөөр төлөөлүүлэх харилцааны хооронд зааг ялгаа байхгүй болоод байна. Үүний улмаас хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй этгээд хэргийн оролцогч нарыг итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлж ХХША-д оролцсоноор дараах гурван төрлийн асуудал үүсэж байна. Үүнд:

1. *Иргэдийн эрх зөрчигдөх:* Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй этгээд бусдыг төлөөлөн ХХША-д оролцох тохиолдолд мэргэжлийн байх шинж алдагдаж, мэдлэг ур чадвар дутагдах асуудал үүсдэг. Тухайлбал, төлөөлүүлж буй этгээдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөв таньж мэдэхгүй байх, цаашлаад мэргэшсэн, оновчтой хууль зүйн зөвлөгөө өгч чадахгүй байх, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсний улмаас төлөөлүүлэгч нь хохирох явдал тохиолддог.

2. *Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад тотгор учрах:* Итгэмжлэгдсэн төлөөлөгч ёс зүйгүй, хариуцлагагүй үйлдэл гаргасан тохиолдолд хариуцлага тооцох эрх зүйн орчин байхгүйн улмаас хэргийн оролцогч болон шүүгч, шүүхийн бусад ажилтнуудын эсрэг ёс зүйгүй үйлдэл гаргахаас гадна ХХША-д оролцох мэдлэг, ур чадвар дутсаны улмаас ХХША удаашрах явдал гардаг. Нөгөө талаас, өмгөөлөгчид ХХША-д итгэмжлэлээр орж, улмаар ХХША-г санаатайгаар удаашруулж, зориуд хугацаа авах зорилгоор “өмгөөлөгч авна” гэсэн шалтаг гарган уг тогтолцоог урвуулан ашиглаж байна.

3. *Хуульчийн мэргэжлийн эрхэд сөргөөр нөлөөлөх:* Мэргэжлийн бус өмгөөлөгч этгээд бусдын эрх ашгийг төлөөлөх нь угаасаа эрсдэлтэй буюу тухайн төлөөлүүлэгчээ хохироосноор хууль зүйн мэргэжлийн үйлчилгээний чанарыг унагах, үйлчилгээний хөлс, төлбөрийг хэт багаар тогтоох, улмаар хуульчдын нэр хүндийг унагах гэх мэт сөрөг нөлөөтэй.

Цаашлаад ИХШХШТХ-ийн 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсэгт “*Өмгөөлөгчөөс өөр этгээдээр төлөөлүүлж байгаа иргэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцохгүй. Биечлэн оролцох тохиолдолд өөрийг нь төлөөлж байгаа этгээдээс татгалзсан тухайгаа шүүхэд бичгээр мэдэгдэнэ.*” гэсэн хязгаарлалтыг тогтоож өгсөн. Иргэний хэргийн шүүхийн практикийг судалж үзэхэд хэрвээ итгэмжлэгдсэн төлөөлөгч, төлөөлүүлэгч нар хамтдаа шүүх хуралд оролцсон тохиолдолд шүүхээс аль нэгийг шүүх хуралд хэргийн оролцогч гэж үзэх ба нөгөөх нь ажиглагчийн байр суурьтай оролцдог. Хэдийгээр дээрх зохицуулалт нь шүүхийн ХХША-г хялбарчилсан, процессыг хөнгөвчилсөн зохицуулалт болсон ч нөгөө талаасаа, хэргийн жинхэнэ оролцогчийн Үндсэн хуулиар олгогдсон шүүх ажиллагаанд биеэр оролцох эрхийг зөрчиж байж болзошгүй юм. Гэвч Монгол Улсын Дээд шүүхээс 2014 онд гаргасан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбарт “хэргийн оролцогч өөрийнхөө төлөөлөгчийг ХХША-д оролцуулсан тохиолдолд тус этгээд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцох эрхээсээ татгалзсан гэж үзнэ. Хэргийн оролцогчийг төлөөлөгчийн хамт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах явдал шүүхийн практикт байдаг ба энэ нь утга агуулгаараа буруу” гэж тайлбарласан байна.

Харин Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.7-д “*Итгэмжлэлээр төлөөлүүлж байгаа хэргийн оролцогч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцохгүй байж болно.*” гэж зохицуулсан. Агуулгын хувьд хэргийн оролцогч хэдийгээр өөрийгөө төлөөлүүлэхээр итгэмжлэл олгосон ч тухайн хэрэгт өөрөө биечлэн оролцсон ч болно, оролцохгүй байсан ч болно гэж үзэж байна. Энэ нь тухайн хүнийг шүүх хуралд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд заавал оролцохыг шаардахгүй гэсэн утгаар ойлгогдож байна. Захиргааны хэргийн шүүхээс ч шүүх хуралд хэргийн жинхэнэ оролцогч, итгэмжлэгдсэн төлөөлөгчтэйгөө хамтдаа ирсэн нөхцөлд хамтад нь шүүх хуралд оролцуулдаг, итгэмжлэл олгосон гэх үндэслэлээр хэргийн оролцогчийн эрхийг хязгаарладаггүй.

## БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бусад улс орны хувьд хэргийн оролцогч нь ХХША-д өөрийн биеэр болон бусдаар төлөөлүүлэн оролцохыг хэрхэн зохицуулж буйг харьцуулан судлав.

Эрх зүйн өндөр хөгжилтэй орнууд өмгөөлөгч бус этгээд өмгөөлөгчийн нэгэн адил ХХША-д оролцохыг бүрэн хориглох, эсвэл зөвхөн анхан шатны хөнгөн

хэрэгт оролцохыг зөвшөөрсөн байдлаар хязгаарлаж өгсөн байна. Учир нь ХХША нь материаллаг болоод процессын эрх зүйн өндөр мэдлэг шаардах нарийн төвөгтэй харилцаа тул хууль зүйн мэргэжлийн этгээдийн туслалцаа зайлшгүй шаардлагатай.

### Зарим орны хууль эрхзүйн орчны харьцуулалт

№	Улс	Хэргийн оролцогч өмгөөлөгчгүйгээр дангаараа биечлэн оролцох боломжтой эсэх	Өмгөөлөгч биш этгээдээр өөрийгөө төлөөлүүлэх боломжтой эсэх	Сайн дураар бусдаар төлөөлүүлэх бол зөвхөн өмгөөлөгчөөр төлөөлүүлэх	Шүүхэд хандсан бол заавал өмгөөлөгч хөлслөх
1	АНУ	+	-	+	-
2	ХБНГУ	- Amtsgericht буюу анхан шатны хөнгөн хэрэг шийдвэрлэдэг дүүргийн шүүхэд өмгөөлөгчгүйгээр өөрийн биеэр оролцохыг зөвшөөрнө.	-	-	+
3	Япон Улс	+	- Шүүхийн зөвшөөрлөөр эсвэл хуульд заасан онцгой тохиолдолд анхан шатанд хялбар төрлийн хэрэг дээр болно.	+	-
4	ОХУ	+	ОХУ-ын 2002 оны Иргэний процесс хуулийн 48-р зүйл болон 49-р зүйлд зааснаар өөрийн болон төлөөлөгчөөрөө дамжуулан ХХША-д оролцоно, төлөөлөгч нь итгэмжлэл олгогдсон эрх зүйн чадамжтай этгээд байна.	- ОХУ-ын 2015 оны Захиргааны процессын хуулийн 54-р зүйл болон 55-р зүйлд ХХША-д оролцох төлөөлөгч нь өмгөөлөгч эсхүл эрх зүйн бүрэн чадамжтай эрх зүйн дээд боловсролтой этгээд байна.	-

## БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй итгэмжлэгдсэн төлөөлөгч ХХША-д иргэн болон хуулийн этгээдийг төлөөлөхийг бүр мөсөн хориглох зохицуулалтыг хуульд оруулах, мөн хуулийн этгээдийг итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөх хуулийн зохицуулалтыг ч заавал хуульч, эрх зүйч хүнээр төлөөлүүлэхийг өөрчлөх гэсэн санал, байр сууриуд судалгааны явцад ихээр хөндөгдсөн. Гэвч судалгааны багийн зүгээс энэхүү тогтолцоог гэнэтийн буюу нэг удаагийн шийдвэрээр, богино хугацаанд зогсоох, хориглох нь эрсдэлтэй учир эхний ээлжид тодорхой хүрээ хязгаар тогтоох замаар хязгаарлах нь зохистой гэж үзсэний үндсэн дээр дараах бодлогын зөвлөмжийг дэвшүүлж байна. Ингэхдээ цаашдын хөгжлийн чиг хандлага, асуудлын тулгамдсан байдал зэргийг харгалзан зөвлөмжүүдийг дараах байдлаар ангилан тодорхойллоо.

### (i) ОЙРЫН ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ ЗӨВЛӨМЖҮҮД

Нэг. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах талаар:

- ИХШХШТХ-д “төлөөлөл” болон “өмгөөлөл”-ийн чиг үүрэг, ялгааг тодорхой оруулах буюу өмгөөлөгч болон итгэмжлэгдсэн төлөөлөгч нарын эрх зүйн байдал, тэдгээрийн ХХША-д эдлэх эрх үүргийг тодорхой ялгаж, зааглан зохицуулах шаардлагатай. ОХУ-ын Иргэний процессын хуулийн 54 дүгээр зүйлд Төлөөлөгчийн эдлэх эрхийг нарийвчлан тодорхойлсон нь 2016 онд батлагдсан манай улсын ЗХШХШТХ-ийн 28 дугаар зүйлд заасан зохицуулалттай адил төстэй байгаа юм. Эндээс харахад, ЗХШХШТХ-ийн 28 ба 30

дугаар зүйлд төлөөлөгч болон өмгөөлөгчийн эрх, үүргийг тодорхой зааж өгсөн байдаг. Төлөөлөгчийн эдлэх эрхээс ялгагдах, зааглагдах өмгөөлөгчийн эрх, үүргийн гол агуулга нь хуульчийн мэргэжлийн ур чадвар, мэдлэг, хууль хэрэглээний дадал, туршлага шаардах процесс ажиллагаануудыг явуулах боломжтойгоор хуульчлагдсанд байна. Тиймээс одоогийн мөрдөгдөж буй ИХШХШТХ-д захиргааны процессын хуулийн дээрх зохицуулалттай адилаар өмгөөлөгч болон төлөөлөгч хоёрын эрх, үүргийг тодорхой зааж өгөх хэрэгтэй.

- ИХШХШТХ-ийн 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсэгт заасан “Өмгөөлөгчөөс өөр этгээдээр төлөөлүүлж байгаа иргэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцохгүй. Биечлэн оролцох тохиолдолд өөрийг нь төлөөлж байгаа этгээдээс татгалзсан тухайгаа шүүхэд бичгээр мэдэгдэнэ.” гэсэн нь зохицуулалтыг ЗХШХШТХ-ийн 27.7-ын жишигт нийцүүлэн “Итгэмжлэлээр төлөөлүүлж байгаа хэргийн оролцогч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцохгүй байж болно.” буюу биечлэн оролцсон тохиолдолд хязгаарлалт хийхгүй байхаар зохицуулах.
- Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй өмгөөлөгч нь ХХША-д бусдыг итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөхийг хориглосон зохицуулалтыг процессын болон Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд тусгах.

**Хоёр. Төлөөллийн зорилгыг тодорхой болгох талаар:**

- ХХША-д иргэнийг төлөөлөх этгээд нь итгэмжлэгдсэн төлөөлөгчийг байнгын шинжтэй, төлбөртэйгөөр эрхлэхийг хориглох буюу энэ харилцаа нь ашгийн бус байх гэдэг зохицуулалтыг ИХШХШТХ болон ЗХШХШТХ-д тодруулж оруулах. Үүнээс гадна ашиг олох зорилгоор итгэмжлэлийн үндсэн дээр бусдыг ХХША-д төлөөлсөн бол тэнд хариуцлага тооцох боломжтой зохицуулалтыг бий болгох.

**Гурав. Хариуцлагын тогтолцооны талаар:**

- Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхгүй этгээд итгэмжлэлээр төлөөллийн үйл ажиллагаа эрхлэхдээ өөрийгөө

хуульч, өмгөөлөгч гэж хэргийн оролцогч, иргэдэд ойлгуулсан үйлдэлд ХЭЗБТХ-ийн 69.1-р зүйлд заасны дагуу хуульч мэргэжлийн нэрийг хэрэглэх эрхгүй этгээд хуульч мэргэжлийн нэрийг хэрэглэсэн гэдэг үндэслэлээр захиргааны хариуцлагын журмаар шалгаж шийдвэрлэж байх, эсхүл Эрүүгийн шинэчилсэн найруулгын 21 дүгээр зүйлийн 21.8 дахь хэсгийн 1, 2-т заасны дагуу хохирол учруулсан тохиолдолд хамаарахаар бол эрүүгийн журмаар шалган шийдвэрлэж байх эрх зүйн тогтолцоо хандлагыг тогтоох, Хуульч хэрэгжүүлэгч Цагдаагийн байгууллагад таниулах, сурталчлах нөлөөллийн ажлыг хийх.

## (ii) УРТ ХУГАЦААНД БАРИМТЛАХ ЗАРЧМЫН ШИНЖТЭЙ БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

**Нэг. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид тавигдах шаардлагын талаар:**

- Харьцуулсан судалгааны үр дүнг үндэслэн, ХХША-д бусдын эрх ашгийг төлөөлөн хамгаалах, хууль зүйн туслалцаа үзүүлэх этгээд нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй, тодорхой шалгуур, шаардлагыг хангасан өмгөөлөгч байх ёстой гэсэн зарчмыг нийгэм, эдийн засгийн хүчин зүйлстэй уялдуулан цаашид баримтлах.

**Хоёр. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй этгээд ХХША-д төлөөлөн оролцох талаар:**

- Япон Улсын хууль зүйн практикт хэвшсэн туршлагад үндэслэн татвар, оюуны өмч, техник, технологийн гэх мэт нарийн мэдлэг, чадвар шаардсан хэрэг маргаан дээр өмгөөлөгчөөс өөр этгээд бусдыг төлөөлөх боломжийг хуулиар бий болгох нь зүйтэй.
- Хуулийн этгээдийг төлөөлөх асуудал дээр одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ИХШХШТХ болон ЗХШХШТХ-ийн зохицуулалтыг ерөнхийдөө хэвээр хадгалах нь зүйтэй. Учир нь тухайн байгууллага, компанийн асуудал, эрх зүйн байдлыг сайн мэддэг, ажил хариуцсан чиглэлээрээ туршлагатай, салбарын асуудалдаа мэргэшсэн ажилтан шүүхэд төлөөлөх нь илүү үр дүнтэй, хэргийн оролцогчийн эрх ашиг илүү сайн хамгаалагдах болно.